



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2016 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/157

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар бүлгийн 2.4.1 дэх заалт, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9, 3 дугаар хэсгийн 3.1.3, 4 дүгээр хэсгийн 4.4.15 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Багануур дүүргийн зам талбайн цас мөс хайлуулах зориулалтын бодис, давсны нөөц дууссантай холбогдуулан цас мөс хайлуулах зориулалтын бодис худалдан авах ажлыг 2016 оны 12 дугаар сарын 09-ний дотор зохион байгуулж, дүүргийн нутаг дэвсгэрийн зам замын байгууламжийг халтиргаа гулгаагүй болгох арга хэмжээ авч ажиллахыг Багануур дүүргийн Засаг дарга /Ц.Сандаг-Очир/-д даалгасугай.

2. Цас, мөс хайлуулах зориулалтын бодис худалдан авах гэрээ, гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн 2016 оны 12 дугаар сарын 14-ний дотор Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд ирүүлэхийг Багануур дүүргийн Засаг дарга /Ц.Сандаг-Очир/-д үүрэг болгосугай.

3. Багануур дүүрэгт цас мөс хайлуулах зориулалтын бодис худалдан авахад шаардагдах 9,000,000 /есөн сая төгрөг/-ийг хот тохижилтын бусад зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч Д.Булганд зөвшөөрсүгэй.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА *[Signature]* ГАНТӨМӨР



1110300600